

Говь Алтай аймаг дахь Төрийн аудитын газар

Гүйцэтгэлийн аудитын тайлан

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2017 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ГАГ-ГАА-/2018/01-ГА/



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 47%-ИЙГ ДЭМЖЛЭГ, ЗЭЭЛ
ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛСАН НЬ ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД 11 ДАХИН
ӨССӨН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ, МӨН ДОТООДЫН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Алтай хот

2017 он

Àãóóëãà

Òàëëàíà áýëðäýñýí:

Ãíãü-Àëðàë àëíàëéí Àóãëðòóí
ãàçòóí
III áàã

Дарга, Тэргүүлэх аудитор
Х.Түвшинбаяр
Утас: 99489309

Аудитын менежер
Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677

Ахлах аудитор
Д.Цэрэнханд
Утас:9914799

Аудитор
Г.Цэцэгмаа
Утас: 99489399

2018 оны 04 дүгээр нàð

Àóãëðòóí ðàëëàíðàë äèëáíðòé
àñóóãëãàð íýíæ ðíäðóóëãð, àñóóæ
ëàãëãð çúëë áàëããë 70483413,
70484055 äóããàðòóí óðàñ, 70484030
ãóããàðòóí ðàëñãàð ðàðëëððàíà óó.

Õàýà:

Говь-Алтай аймаг
Есөнбулаг сум
Баянхайрхан баг

АОÄÈÒÓÍ ÇÍÐÈÈÒ, ÕÀÌÄÑÀÍ ХҮÐÝÝ, ÀÐÃÀ
ÇúÉ.....

НЭГ: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭН
ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ
БАЙНА.

ХОЁР: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН 47% ДЭМЖЛЭГ, ТУСЛАМЖ, ЗЭЭЛ
ОЛГОХОД ЗАРЦУУЛАГДЖЭЭ.

ГУРАВ: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭНД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗГ	Засгийн газар
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчийн Хурал
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗД	Засаг дарга
ААН	Аж ахуй нэгж
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
СС	Сангийн сайд
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХА	Харьцуулалтын арга
ОНО	Олон нийтийн оролцоотой
ШГБ	Шууд гэрээ байгуулах
ТАХ	Төсөл арга хэмжээ

ᠠᠣᠶᠢᠯᠠᠭᠤ ᠴᠢᠳᠡᠭᠡ, ᠳᠠᠢᠠᠳᠦᠨᠠᠢ ᠪᠦᠳᠦᠭᠦ, ᠠᠳᠠᠠ ᠴᠢᠳᠡ, ᠠᠦᠳᠦᠳᠦᠭᠦ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын дэд зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн үү.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд хяналт тавьж ажилласан уу.

Аудитын явцад “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийж тайлагнана.

Аудитын хамарсан хүрээ: Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, аймаг болон сумдын ЗДТГ, бусад холбогдох байгууллага, хуулийн этгээд хамрагдлаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Үүнд:

Аудит хийж буй асуудлуудыг нэгтгэж тайланд тусгахдаа дараах арга зүйг ашиглаж баримтжууллаа.

- Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлууд нь Нийгэм эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн мөрийн хөтөлбөрт тусгагдсан эсэх
- Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх
- Орон нутгийн орлогын дансны хуулгыг ажлын санхүүжилтийн хуваарь, гэрээний дүнтэй тулган баталгаажуулсан
- Төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэх гэрээг гэрээний батлагдсан загвартай тулган баталгаажуулсан
- Орон нутгийн хөрөнгө оруулалт нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалд заасан ТАХ-нд зарцуулагдсан эсэх

БҮЛЭГ 1: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭН ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

1.1 Аймгийн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, нийгэм эдийн хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй 6 ТАХ байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ:

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 05 -ны өдрийн 10 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар 109,933.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-г анх баталсан бөгөөд 2 удаа тодотгол хийгдсэн байна.

2017 оны 12 дугаар сарын 5 өдрийн 86 дугаар тогтоолоор 911,733.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 19 хөрөнгө оруулалтын ТАХ-г санхүүжүүлэхээр тодотгон баталсан байна. Үүнээс “Бигэр сумын Өөшийн услалтын системийн зураг төсөв боловсруулах” ажил нь он дамжсан өмнөх оны ажил байна.

Нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй 2 ТАХ-г аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс ИТХ-д батлуулахаар өргөн барьсан ба аймгийн ИТХ нь 4 ТАХ-г хэлэлцэн шууд баталснаар нийт 6 ТАХ-г баталжээ.

Хүснэгт №1: Үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй ТАХ /мян.төг/

Аймгийн ИТХ-аас баталсан		Аймгийн ЗДТГ-аас оруулж батлуулсан	
Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
Хүнхэр амралтын газрын засварын дэмжлэг	15,000.0	Аймгийн ЗДТГ-ын суудлын авто машин	13,400.0
Монгол улсын баатар Жанчивын талбайн урсгал засвар	5,600.0	Алтай радио дэмжлэг	49,110.6
Бусад /Шүүх, прокурорт дэмжлэг/	20,000.0		
Алтай хотын гэр хорооллын хашааны өнгө үзэмжийг сэргээн засварлахад дэмжлэг	10,000.0		
дүн	50,600.0		62,510.6

Авто зам, барилга байгууламжийн ТАХ:

Аймгийн ИТХ-аар авто зам, гүүрийн байгууламжийн ажилд 9 ТАХ-г 243,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ. Үүнд: Есөнбулаг сумын 1-р цэцэрлэг, 3-р сургуулийн урд талд 3860м² хатуу хучилттай авто зогсоол барих, Алтай хотын хатуу хучилттай авто замын нөхөөс, Алтай хот дотор явган зам барих зэрэг 3 ТАХ нь он дамжсан байна.

Хийхээр төлөвлөсөн авто зам, гүүрийн байгууламжтай холбоотой ТАХ нь нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт бүрэн тусгагдсан байна.

1.2 Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шаардлага хангасан төсөл арга хэмжээг батлах шаардлагатай байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ:

Хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан 19 ТАХ-нээс ТЭЗҮ, зураг төсөв, эх үүсвэр, хүрэх үр дүн зэргийг урьдчилан тооцсон эсэхийг нягталж үзэхэд доор дурьдсан ТАХ-г эс тооцвол бусад ТАХ шаардлагад нийцсэн байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-аас "Гэгээн нуур-Цэвэр ус" ОНӨААТҮГазар, "Алтай" радио зэрэг байгууллагуудад урсгал үйл ажиллагааг санхүүжүүлэхээр баталсан нь Төсвийн тухай хуулийн 27.4.4¹ дахь заалт, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ыг
- Мөн Шүүх, Прокурорын газарт 20,000.0 мянган төгрөгийн, Цагдаагийн газарт 25,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр баталсан нь Төсвийн тухай хуулийн 6.6.6² дахь заалтыг
- Хүнхэр амралтын газрын засварт 15,000.0 мянган төгрөгийг, Монгол Улсын баатар Жанчивын талбайн засварт 5,600.0 мянган төгрөгийг, нийт 20,600.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг ТЭЗҮ боловсруулаагүй байхад санхүүжүүлэхээр баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Авто зам, гүүрийн байгууламжтай холбоотой 9 ТАХ-ны ТЭЗҮ, зураг төсөв, эх үүсвэр, хүрэх үр дүн зэргийг урьдчилан тооцсон байна.

БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 47% ДЭМЖЛЭГ, ТУСЛАМЖ, ЗЭЭЛ ОЛГОХОД ЗАРЦУУЛАГДЖЭЭ.

2.1 Гүйцэтгэгч сонгон шалгаруулах үйл ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу хийгдсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ:

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 911,733.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ-ээс 2 ТАХ хэрэгжээгүй буюу ХАА зарлаагүй, 4 ТАХ нь ХАА зарлах шаардлагагүй буюу байгууллагуудад олгосон дэмжлэг тусламж, 5 ТАХ нь шууд худалдан авалт хийсэн, 4 ТАХ нь тендер шалгаруулалтын онцгой журам буюу харьцуулалтын аргаар, 3 ТАХ нь нээлттэй тендер зарласан боловч шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй тул шууд гэрээ байгуулах эрх олгосон байна.

Зөвлөх үйлчилгээний аргаар өмнөх онд хэрэгжсэн Бигэр сумын Өөшийн услалтын системийн зураг төсвийн сонгон шалгаруулалт хийсэн байна.

График1: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ХАА /тоогоор/



¹ хөрөнгө оруулалтын төсөл боловсруулахад тавигдах ерөнхий болон тусгай шаардлага

² тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх

³ хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

Шууд худалдан авалт хийсэн ТАХ-ны талаар

Аймгийн Засаг даргын захирамжаар доорх ТАХ-г төсөл хэрэгжиж байгаа төсвийн шууд захирагчид эрхийг шилжүүлсэн байна.

Нийт хэрэгжсэн төслийн 42% нь шууд худалдан авалт хийсэн байна. Үүнд:

- Хилийн 0214 дүгээр ангийн хилийн заставуудад сансарын холбоон ВСАТ систем суурилуулахад шаардлагатай байгаа тоног төхөөрөмж авах /61,252.8 мянган төгрөг/ - Энэ ТАХ нь ТБОНАХБАҮХАТХ-д заасны дагуу төрийн нууцын жагсаалт, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой ажил гүйцэтгэсэн тул шууд худалдан авалт хийсэн ба аудитад хамруулаагүй. /Хилийн 0214-р ангийн албан тоотыг хавсаргав/
- "Гэгээн нуур-Цэвэр ус" ОНӨААТҮГазрын ус тээвэрлэх ачааны автомашины засвар /10,000.0 мянган төгрөг/, Монгол Улсын баатар Жанчивын талбайн урсгал засвар /5,600.0 мянган төгрөг/, Алтай хотын гэр хорооллын хашааны өнгө үзэмжийг сэргээн засварлахад дэмжлэг /10.000 мянган төгрөг/ зэрэг ТАХ-үүд нь босго үнээс хэтрээгүй төсөвт өртөг 10,000.0 мянган төгрөг дотор тул шууд худалдан авалт хийсэн байна.
- Харин Хүнхэр амралтын газрын засварын дэмжлэг /15,000.0 мянган төгрөг/- Аймгийн засаг даргын 2017 оны А/194 тоот захирамжаар шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг олгосон нь ТБОНАХБАҮХАТХ-ийн 8.2⁴ дахь заалт, Засгийн газрын 2013 оны 68-р тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай"-ыг зөрчсөн үйл ажиллагаа болжээ.

Авто зам, барилга байгууламжийн ТАХ:

Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5 ТАХ-ны "Спорт цогцолборын автомашины зогсоолын тэмдэг тэмдэглэл хийх" ажил нь нээлттэй тендер шалгаруулсан ба 4 ТАХ нь төсөвт өртөг 10,000.0 мянган төгрөгөөс доош тул шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлжээ.

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хийгдэх ажлуудад тендер шалгаруулалтыг хийхдээ тендерийн урилгыг өдөр тутмын Зууны мэдээ сонин болон www.e-procurement.mof.gov.mn, www.govi-altai.gov.mn, www.meps.gov.mn вэб сайтуудад тендерийн урилга болон баримт бичгүүдийг нийтэлж ажилласан байна.

2.2 Төсөл арга хэмжээний зураг төсөв урьдчилан хийгдсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ:

Аймгийн хэмжээнд хэрэгжсэн 17 ТАХ-ээс ТЭЗҮ, зураг төсөв боловсруулсан 9 ТАХ, боловсруулах шаардлагагүй /дэмжлэг тусламж/ 6 ТАХ, боловсруулаагүй 2 ТАХ байна. ТЭЗҮ боловсруулаагүй, юу хийх нь тодохой бус ТАХ нь Хүнхэр амралтын газрын засвар /15,000.0 мянган төгрөг/, Монгол Улсын баатар Жанчивын талбайн урсгал засвар /5,600.0 мянган төгрөг/ зэрэг байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁵ дэх заалтыг зөрчжээ.

Хүснэгт №2: ТАХ-ны урьдчилсан зураг төсөв, техникийн тодорхойлолт хийгдсэн талаар /тоогоор/

4 энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.

⁵ хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана



Авто зам, барилга байгууламжийн ТАХ:

Авто замын хөрөнгө оруулалттай холбоотой 8 ТАХ-ны зураг төсөв, ТЭЗҮ бүрэн хийгдсэн байна.

2.3 Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ:

Аймгийн 2016 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын 4% буюу 35,201.0 мянган төгрөг дэмжлэг тусламжинд зарцуулагдаж байсан бол 2017 онд 47% буюу 391,938.0 мянган төгрөг дэмжлэг, зээл олгоход зарцуулагдсан нь хөрөнгө оруулалт бус зээл, дэмжлэг тусламжинд зарцуулагдах хандлага нэмэгдсээр байгааг харуулж байна. Энэ нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаал “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хяналт, тайлагналтын журам”-ыг баримталж ажиллахгүй байгааг харуулж байна.

Засгийн газраас Жижиг дунд үйлдвэрлэл, хоршоог хөгжүүлэх чиглэлээр манай аймгийн сумдын сум хөгжүүлэх сангийн дансанд 4,326.9 сая төгрөгийн эх үүсвэрийг санхүүжүүлсэн байна. Гэтэл сумдын сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй, графикт хугацаандаа зээл хүүгээ төлөөгүйд тогтоосон төлбөрийн акт 1,718.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй, мөн аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас олгосон 200.0 сая төгрөгийн зээл эргэн төлөгдөөгүй байна. Гэтэл орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс шалгуур үзүүлэлтийг харгалзахгүй, сонгон шалгаруулсан баримт материал, хурлын тэмдэглэл, хорооны шийдвэргүйгээр 200.0 сая төгрөгийн зээлийг дахин олгожээ. Энэ зээлдэгч нар нь гэрээнд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулаагүй, эргэн төлөлт огт хийгээгүй байхад эрх бүхий албан тушаалтан түүнд хяналт тавьж ажиллаагүй байна.


Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийг журмын дагуу төлүүлэх үүргээ хэрэгжүүлэхгүй мөртлөө бусад эх үүсвэрээс мөн адил нөхцөлтэй зээлийг олгож байгаа нь аймаг орон нутгийн хөгжилд оруулах хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулах санхүүгийн зөрчлийг жил бүр нэмэгдүүлэх эрсдлийг бий болгож байна.

Хөрөнгө оруулалтаар биетээр хэрэгжсэн ТАХ-г газар дээр нь очин, ТЭЗҮ, зураг төсөвтэй тулган баталгаажуулахад чанар байдал, боломжийн одоогоор эвдрэл гэмтэлгүй үйл ажиллагаанд хэвийн ашиглаж байна. Он дамжсан буюу 2017-2018 онд хийхээр төлөвлөсөн Багийн үйлчилгээний нэдсэн цогц төвийн шинэ барилга /"Марал-Алтай" өрхийн ЭМТөвтэй /-ын ажлын суурийг тавьсан байна. Мөн Тонхил сумын Алтансоёмбо багийн төвийг цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй болгох ажил 20%-тай буюу бэлтгэл ажил хангагдах шатандаа явж байна. / Тонхил сумын Засаг даргын албан тоотыг хавсаргав/

Хөрөнгө оруулалтаар хийхээр төлөвлөн, санхүүжүүлсэн ТАХ-г ангилж үзвэл:

- Нийт хөрөнгө оруулалтын 147,229.4 мянган төгрөг буюу 18 % нь автомашин, багийн засаг даргыг унаажуулахад
- Шинээр барилга байгууламж барихад 30,000.0 мянган төгрөг буюу 4%
- Тоног төхөөрөмж худалдан авахад 61,253.0 мянган төгрөг буюу 7 %
- Орон нутгийн болон улсын төсвийн байгууллагад дэмжлэг олгоход 191,938.0 мянган төгрөг буюу 23%
- ЖДҮ дэмжих зээл олгоход 200,000.0 мянган төгрөг буюу 24 %
- Тохижилт, ногоон байгууламжын хамгаалалтын ажилд 70,044.7 мянган төгрөг буюу 8 %
- Барилгын засварын ажилд 30,142.0 мянган төгрөг буюу 4%
- Эрчим хүчний эх үүсвэр бий болгоход 91,296.4 мянган төгрөг буюу 11 %
/арилжааны банкинд эксроу дансанд байршиж байна./

График №1: Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ны гэрээ, түүний санхүүжилт /мян.төг/



Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, гэрээний үүргийн биелэлтийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✚ Аймгийн ИТХ-ийн 2017 оны 12 сарын 04-ны 07 дугаар тогтоолоор Монгол Улсын баатар Жанчивын талбайн урсгал засварт 5,600.0 мянган төгрөгийг батлуулсан боловч, тухайн ТАХ-г санхүүжүүлээгүй байна. Харин уг ажлын оронд аймгийн төвийн замын хашлага будах ажлыг шууд худалдан авалтаар 5,141.7 мянган төгрөгөөр санхүүжүүлж, “Алтай

хотын тохижилт үйлчилгээний газар"-тай гэрээ байгуулаагүй гүйцэтгүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5⁶ дахь заалтыг зөрчжээ.

- ✚ Хэрэгжсэн хөрөнгө оруулалт ТАХ-ний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ нь ТБОНӨБАҮХАТХ-ын 5 дугаар бүлэгт заасны дагуу дараах ерөнхий болон тусгай нөхцлийг бүрэн тусгасан эсэхийг давтан тооцож үзэхэд: Гэрээ байгуулсан 9 ажлаас 2 ажлын гэрээнд төлбөр хийх нөхцөлийг үе шаттай тусгаагүй, 4 ажилд захиалагчийн хяналтыг хийх талаар заалт тусгаагүй байгуулжээ.
- ✚ Хөрөнгө оруулалтаас ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр олгосон зээлийг сонгон шалгаруулсан баримт материал, хурлын тэмдэглэл, хорооны шийдвэр зэрэг нотлох баримтыг ирүүлээгүй нь журмын дагуу шалгаруулсан эсэхийг нотлох боломжгүй байна.
- ✚ ЖДҮ-г хөгжүүлэх чиглэлээр олгосон зээлийн явц хэрэгжилтийг бодит байдал дээр тулган үзэхэд үйл ажиллагаа нь огт эхлээгүй, тоног төхөөрөмж, түүхий эд бэлтгэсэн эсэхийг нотлох боломжгүй 1 ААН /"Бага Үнэгтэй" ХХК/, үхэр авсан гэх боловч аймгийн нутаг дэвсгэрт байхгүй, үйл ажиллагаа явуулж байгаа эсэх нь тодорхой бус 1 ААН /Могойн бор ХХК/, тоног төхөөрөмж, түүхий эд материалаа бэлдсэн үйл ажиллагаа нь эхлээгүй 2 ААН / "Удмын Ундраа" ХХК, "Энонобэ индрасти" ХХК/ байна.
- ✚ Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр олгосон зээлнээс "Удмын ундраа" ХХК нь 2,100.9 мянган төгрөгийг, "Ханлиг Тайшир" ХХК нь 1,980.7 мянган төгрөгийг, "Эконобэ индрасти" ХХК 500.0 мянган төгрөгийг, Бага Үнэгтэй ХХК нь 310.5 мянган төгрөг, "Могойн бор" ХХК 631.2 мянган төгрөг нийт 5,523.4 мянган төгрөгийн хүүгийн төлбөр, үндсэн зээлийг гэрээт хугацаандаа төлөөгүй байна.
- ✚ "Алтай хотын гэр хорооллын хашааны өнгө үзэмжийг сэргээн засварлах" ТАХ-г 4 хоног хугацаа хоцорч хүлээлгэн өгсөнд 40.0 мянган төгрөг, Аймгийн ЗДТГ-ын суудлын авто машиныг 31 хоног хугацаа хоцорч хүлээлгэн өгсөнд 207.5 мянган төгрөг, Аймгийн цагдаагийн газарт автомашиныг 7 хоног хугацаа хоцорч хүлээлгэн өгсөнд 87.5 мянган төгрөг, нийт 335.0 мянган төгрөгийн алдангийг төлүүлээгүй байна.

Авто зам, гүүрийн байгууламжийн талаар:

- ✚ ""Арвин бүхий мэдээллийн самбар байрлуулах" ажлыг гэрээнд заасан хугацаанаас 42 хоног -Өргөө" Констракшн ХХК-ны гүйцэтгэсэн улсын чанартай авто замтай огтлолцож байгаа орон нутгийн чанартай авто замын салаа уулзваруудад хоёр талдаа мэдээлэл хугацаа хоцорч хүлээлгэн өгсөнд 147.0 мянган төгрөг, "Алтай хотын авто зам дагуу босоо тэмдэг байрлуул
- ✚ ах" ажил 42 хоног хугацаа хоцорч хүлээлгэн өгсөнд 210.0 мянган төгрөг, нийт 357.0 мянган төгрөгийн алдангийг төлүүлээгүй байна.

2.4 Хүлээлгэн өгсөн төсөл арга хэмжээг холбогдох байгууллагад бүртгэлд бүрэн тусгасан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд 820,075.8 мянган төгрөгийн ТАХ-г хэрэгжүүлж санхүүжүүлснээс тухайн холбогдох байгууллагад 268,527.1 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авсан, 229,905.8 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авах шаардлагагүй, 200,000.0 мянган төгрөгийг авлагад тусгасан, 121,642.9 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авах болоогүй буюу ТАХ хэрэгжиж дуусаагүй байна.

Авто замын хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлуудаас 327,651.5 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг орлого авсан, 34,924.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авах шаардлагагүй /хэвтээ, босоо замын тэмдэг, стадионы гадна засвар/ ажил байна.

Хүснэгт-№3: Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал

6 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/

Орлого авсан эсэх		Мөнгөн дүн /мян.төг/
ОНТХО	Орлогод бүртгэсэн	268,527.1
	Орлого тусгах шаардлагагүй	229,905.8
	Авлага тусгасан	200,000.0
	Дуусаагүй ТАХ	121,642.9
	Дүн	820,075.8
АВТО зам	Орлогод бүртгэсэн	327,651.5
	Орлогод тусгах шаардлагагүй	34,924.0
	Дүн	362,575.5

**БҮЛЭГ 3: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНД ТАВИХ ХЯНАЛТ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

3.1 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ТАХ-нд захиалагч хяналт тавьж ажилласан эсэхийг нотлох боломжгүй, авто замын хөрөнгө оруулалтын ажилд хяналт хийгээгүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын ТАХ:

Аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн хэлтсээс явц бүрт хяналт тавьж ажилласан гэх боловч, бодит байдал дээр хяналт шалгалт хийсэн эсэхийг нотлох хурлын тэмдэглэл, үүрэг даалгавар өгсөн баримт материал ирүүлээгүй байгаа нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын 5.2⁷ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй болохыг харуулж байна.

ЖДҮ дэмжих чиглэлээр олгосон зээлийн хэрэгжилт, явцад хяналт шалгалтыг хагас жилээр хийгээгүй байгаа нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн 78 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 7.1⁸ дахь заалтыг мөрдөж ажиллаагүй байгааг харуулж байна.

Солонго хорооллыг хайсжуулах, Багийн үйлчилгээний нэдсэн цогц төвийн шинэ барилга /"Марал-Алтай" өрхийн ЭМТөвтэй/-ын ажлуудын явц гүйцэтгэлд ГХБХБГ-аас хяналтыг тавьж ажилласан байна. Хяналт хийх явцад солонго хорооллын хаалга зураг төсөвт тусгагдсан байршлаас өөр газарт хийгдсэн байсан зөрчлийг арилгуулж ажилласан байна.

Авто зам, гүүрийн байгууламжын ТАХ:

Авто замын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж хүлээн авсан 173,136.9 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн 8 ТАХ-нд захиалагч болон мэргэжлийн байгууллагаас хяналт тавьж ажиллаагүй байна. Энэ авто замын тухай хуулийн 34.1⁹ дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

МХЕГ-ын 2016 оны 12 сарын 02-ны өдрийн 1/3259 тоот албан хүсэлтэд хөрөнгө оруулалтын хяналтын ажлын санхүүжилтийг гүйцэтгэлээр санхүүжүүлэхээр хүсэлтийг аймгийн Засаг даргад тавьсан боловч аймгийн МХГ хяналт тавиагүй, гүйцэтгэлээ ирүүлээгүй тул хяналтын зардлыг олгоогүй байна.

3.2 Дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

⁷ Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана

⁸ Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалтын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь зээлийн гэрээний биелэлт, хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгжийн төслийн хэрэгжилтэнд хагас, бүтэн жилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэгтэй.

⁹ Авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах, хамгаалах, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг авто замыг өмчлөгч, эзэмшигч, зам хариуцагч байгууллага, Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасны дагуу мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны Засаг дарга, холбогдох албан тушаалтан эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлнэ./

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1¹⁰ дэх заалтын дагуу Дотоод хяналт аудитын алба хяналт шалгалт хийхээр заасан боловч, 2017 онд хэрэгжсэн ТАХ-нд хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна.

Шилэн дансны мэдээллийн талаар

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хугацаа хоцорч, худалдан авах ажиллагааг хугацаанд нь мэдээлсэн байна.

"Шилэн тухай хуулийн 2017 оны хэрэгжилт"-нд хийсэн нийцлийн аудитаар өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой 314,385.4 мянган төгрөгийн 95 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байсан бол аймгийн 2017 оны хөрөнгө оруулалттай холбоотой Засаг даргын 409,600.0 мянган төгрөгийн 18 захирамж гарснаас, цахим хуудсанд огт мэдээлээгүй, 5.0 сая төгрөгөөс дээш 326,374.7 мянган төгрөгийн 10 гүйлгээг мэдээлээгүй байна. Мөн ТАХ авсан иргэн, ААН цахим хуудас, шилэн дансандаа энэ талаар мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 8.2¹¹ дахь заалтын дагуу хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахгүй байгааг харуулж байна.

Аудитаар дараах зөрчлүүд илэрлээ.

Аудитаар нийт 329,467.0 мянган төгрөгийг зөрчлийг илрүүлэн 6,215.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 227,652.3 мянган төгрөгийн зөрчилд 8 заалт албан шаардлага хүргүүлж, 95,600.0 мянган төгрөгийн зөрчилд 3 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллага болон албан тушаалтанд хүргүүлж, 169,467.7 мянган төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 6 санхүүгийн бус үр өгөөж бүртгэлээ.

ДҮГНЭЛТ

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 47%-ИЙГ ДЭМЖЛЭГ,
ЗЭЭЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛСАН НЬ ӨМНӨХ ОНТОЙ
ХАРЬЦУУЛАХАД 11 ДАХИН ӨССӨН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ, МӨН ДОТООДЫН ХЯНАЛТ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА**

ДАРГА , ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБЯАР

10 төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж, гаргах, эрсдлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна

¹¹ Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах шийдвэр гаргаж байна. Үүнд

Зөвлөмж

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Т.Ганзориг танаа

1. Төсвийн шатлалаар техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийгдсэн, нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл арга хэмжээг баталж байх

Аймгийн Засаг дарга С.Гансэлэм танаа

1. Төсөл хөтөлбөр, орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг хууль эрх зүйн хүрээнд үр ашигтай зарцуулж, түүнд тавих хяналтыг сайжруулж ажиллах

Дотоод хяналт аудитын албаны дарга Д.Ганзориг танаа

1. Эрсдлийг үндэслэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд хяналт шалгалт хийж, үр дүнг тооцож, зөрчлийг арилгуулж ажиллах

Төлбөрийн акт

Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Жаргалсайхан, Ерөнхий нягтлан бодогч Т.Энхцэцэг, Хөрөнгө оруулалтын бодлого хариуцсан мэргэжилтэн С.Пагмадулам нарт

1. Гэрээт хугацаанд төлөөгүй үндсэн зээл, хүүгийн төлбөрөө нийт 5,523.4 мянган төгрөгийг аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн 1000500514021 тоот дансанд 2018 оны 07 сарын 15-ны дотор төвлөрүүлэх

Засаг даргын тамгын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Ерөнхий нягтлан бодогч Т.Энхцэцэг, Хөрөнгө оруулалтын бодлого хариуцсан мэргэжилтэн С.Пагмадулам

1. Гэрээт хугацаанд ажилаа хүлээлгэн өгөөгүйд тооцсон алданги 335.0 мянган төгрөгийг аймгийн орон нутгийн орлогын 100050051300 тоот дансанд 2018 оны 07 сарын 15-ны дотор төвлөрүүлэх

Засаг даргын тамгын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Жаргалсайхан, Ерөнхий нягтлан бодогч Т.Энхцэцэг, Хөрөнгө оруулалтын бодлого хариуцсан мэргэжилтэн С.Пагмадулам

1. Гэрээт хугацаанд ажилаа хүлээлгэн өгөөгүйд тооцсон алданги 357.0 мянган төгрөгийг аймгийн орон нутгийн орлогын 100050051300 тоот дансанд 2018 оны 07 сарын 15-ны дотор төвлөрүүлэх

Албан шаардлага

Аймгийн Засаг дарга С.Гансэлэм

1. Журам болон гэрээнд заасны дагуу зээлийн хэрэгжилтийн явц, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн, холбогдох шийдвэрийн хамт Төрийн аудитын газарт 2018 оны 06 сарын 15-ны дотор ирүүлнэ үү
2. Хуульд заасны дагуу автозамын засвар, арчлалт, хамгаалалтанд хяналт тавьж ажиллах

Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ

1. Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл арга хэмжээг ИТХ-д өргөн барьж байх
2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх

3. Нэгдсэн гэрээний загвар ашиглаж хуулийн дагуу гэрээнд тусгагдах заалтуудыг бүрэн тусгаж ажиллах

Мэргэжлийн хяналтын газрын дарга .Б.Түмэнбаатар

1. Хуульд заасны дагуу автозамын засвар, арчлалт, хамгаалалтанд хяналт тавьж ажиллах

Дотоод хяналт аудитын албаны дарга Д.Ганзоригт

1. Аудитаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулж, хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах

ДАРГА , ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Саналд хариу тайлбар хүргүүлэх тухай

Орон нутгийн төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, шийдвэрт ирүүлсэн саналтай танилцлаа. Саналд “Гэрээт хугацаандаа бараагаа хүлээлгэн өгөөгүй Аймгийн ЗДТГ-ын суудлын автомашиныг хүлээж авах комиссын бүрэлдэхүүн бүрдэхгүй хугацаа удааширсан тул холбогдох актыг чөлөөлж өгнө үү” гэжээ.

Энэ төлбөрийн актыг гэрээний үүргийн дагуу тооцсон бөгөөд бусад хугацаа хоцорсон төсөл арга хэмжээнд мөн адил төлбөрийн акт тогтоосон тул чөлөөлөх боломжгүй байна.